



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Багануур-Ус ААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд  
хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** НТАГ-2025/022/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Улаанбаатар хот  
2025 он

Нийслэл дэх Төрийн аудитын газрын дэд дарга Ч.Болд  
Утас: 7000-7734 Цахим хаяг: [boldch@audit.gov.mn](mailto:boldch@audit.gov.mn)  
Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн дарга Х.Түвшинбаяр  
Утас: 315558 Цахим хаяг: [tuvshinbayarkh@audit.gov.mn](mailto:tuvshinbayarkh@audit.gov.mn)  
Аудитын менежер: Я.Алтанцэцэг  
Утас: 325093 Цахим хаяг: [altantsetsegya@audit.gov.mn](mailto:altantsetsegya@audit.gov.mn)  
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Гэрэлт хөхийн тэнцвэр аудит  
ХХК-ийн захирал Д.Баатарсайхан  
Утас: 99099119 Цахим хаяг: [info@ghtaudit.mn](mailto:info@ghtaudit.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54  
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2025.03.14 № 01/294  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

БАГАНУУР УС ААТҮГ-ЫН  
ЗАХИРАЛ Ж.ЭНХБАТ ТАНАА

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Багануур-Ус ААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон эдийн засгийн зорилтот түвшний гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд Азийн хөгжлийн банк, Сангийн яамны дамжуулан зээлдүүлэх зээлийн өглөг 228.0 сая төгрөгийг данснаас хассантай холбоотой урт хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл буурсан байна.

#### Аудитын гол асуудал

Багануур-Ус ААТҮГ нь зорилтот түвшний төлөвлөгөөнд туссан орлогын төлөвлөгөөг 99.2 хувиар биелүүлж, зардлыг 96.3 хувийн гүйцэтгэлтэй зарцуулж, алдагдлыг 144.5 сая төгрөгөөр бууруулж ажилласан байна.

#### Бусад асуудал

Багануур дүүргийн Засаг даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу 4 зорилтын хүрээнд 23 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 82.0 хувийн хэрэгжилттэй гэж тайлагнасан байна.

#### Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

C:\Users\zendeme\OneDrive\Desktop\2025\Word\Баталсан\2025\1425010126.docx

1425010126

## Нийслэлийн Багануур дүүргийн Багануур-Ус ААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



**Нийслэлийн Багануур дүүргийн Багануур-Ус ААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТОДРУУЛГА**

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2024 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон /төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	Үлдэгдэл	
		1 сарын 1	12 сарын 31
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	454,376,234.05	740,394,437.01
1.1.02	Дансны авлага	387,444,937.94	292,150,245.25
1.1.03	Татвар, НДШ-ийн авлага	3,989,957.69	17,288,978.58
1.1.04	Бусад авлага	19,080,022.04	11,273,916.00
1.1.06	Бараа материал	47,778,156.09	53,604,622.52
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	912,669,307.81	1,114,712,199.36
1.2.01	Үндсэн хөрөнгө	7,474,704,207.17	7,248,926,096.31
1.2.02	Биет бус хөрөнгө	3,498,183,999.92	3,503,930,909.09
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	10,972,888,207.09	10,752,857,005.40
1.3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>11,885,557,514.90</b>	<b>11,867,569,204.76</b>
2.1.1.01	Дансны өглөг	869,640.63	0.00
2.1.1.03	Татварын өр	15,816.00	361,842.89
2.1.1.06	Хүүний өглөг	18,826,200.00	0.00
2.1.1.08	Урьдчилж орсон орлого	519,024,693.08	609,510,002.30
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	538,736,349.71	609,871,845.19
2.1.2.01	Урт хугацаат зээл	209,180,000.00	0.00
2.1.2.06	Урт хугацаат өр төлбөрийн дүн	209,180,000.00	0.00
2.2	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>747,916,349.71</b>	<b>609,871,845.19</b>
2.3.01	Өмч: - төрийн	14,021,502,224.49	14,021,502,224.49
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	1,220,561,468.90	1,220,444,108.90
2.3.09	Хуримтлагдсан ашиг	-4,104,422,528.20	-3,984,248,973.82
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	0.00	-107,950,005.62
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	-4,104,422,528.20	-3,876,298,968.20
2.3.11	Эздийн өмчийн дүн	11,137,641,165.19	11,257,697,359.57
2.4	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>11,885,557,514.90</b>	<b>11,867,569,204.76</b>

**2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан**

2024 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон /төгрөгөөр/

Дугаар	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
01	Борлуулалтын орлого (цэвэр)	3,756,986,483.92	4,426,104,259.33
02	Борлуулалтын өртөг	3,877,359,757.32	4,433,171,114.07
03	Нийт ашиг( алдагдал)	-120,373,273.40	-7,066,854.74
05	Хүүний орлого	2,138,756.95	9,537,144.81
08	Бусад орлого	227,684,796.62	280,327,509.82

**Нийслэлийн Багануур дүүргийн Багануур-Ус ААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

08.1	Орлогын дүн	229,823,553.57	289,864,654.63
09	Борлуулалт, маркетингийн зардал	130,026,521.70	168,665,741.99
10	Ерөнхий ба удирдлагын зардал	158,401,410.10	221,128,349.04
12.1	Зардлын дүн	288,427,931.80	389,794,091.03
18	Татвар төлөхийн өмнөх ашиг( алдагдал)	-179,977,651.63	-106,996,291.14
19	Орлогын татварын зардал	213,875.71	953,714.48
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-180,191,527.34	-107,950,005.62
22	Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)	-180,191,527.34	-107,950,005.62

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

2024 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон /төгрөгөөр/

Дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	3,649,076,151.37	4,529,567,662.54
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	3,493,372,063.73	4,354,886,602.89
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	5,888,077.00	1,494,513.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	149,816,010.64	173,186,546.65
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	3,534,853,632.11	4,149,306,664.39
1.2.1	Ажиллагчдад төлсөн	1,360,864,312.16	1,652,170,208.18
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	427,190,387.61	536,233,759.11
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	321,047,885.41	311,591,553.72
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	23,563,684.42	29,970,893.48
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс,сэлбэг хэрэгсэлд төлсөн	82,980,300.00	111,808,700.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	321,631,163.91	432,758,825.59
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	5,294,509.83	5,519,259.83
1.2.9	Бусад мөнгөн зарлага	992,281,388.77	1,069,253,464.48
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	114,222,519.26	380,260,998.15
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	2,138,756.95	9,537,144.81
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	2,138,756.95	9,537,144.81
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	101,983,936.00	103,779,940.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	101,983,936.00	93,779,940.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	10,000,000.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-99,845,179.05	-94,242,795.19
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	14,377,340.21	286,018,202.96
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	439,998,893.84	454,376,234.05
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	454,376,234.05	740,394,437.01

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

2024 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон /төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
----------	-----	---------------------------	---------------------------	--------------------	----------

**Нийслэлийн Багануур дүүргийн Багануур-Ус ААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

2022 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	1,816,924,400.62	1,221,069,116.40	12,204,577,823.87	-3,806,761,234.32	11,435,810,106.57
НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	-117,469,766.54	-117,469,766.54
Залруулсан үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	-180,191,527.34	-180,191,527.34
Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00
Өмчид гарсан өөрчлөлт	12,204,577,823.87	0.00	-12,204,577,823.87	0.00	0.00
Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	-507,647.50	0.00	0.00	-507,647.50
2023 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	14,021,502,224.49	1,220,561,468.90	0.00	-4,104,422,528.20	11,137,641,165.19
НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	228,123,560.00	228,123,560.00
Залруулсан үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	-107,950,005.62	-107,950,005.62
Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00
Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	-117,360.00	0.00	0.00	-117,360.00
2024 оны 12 сарын 31-р үлдэгдэл	14,021,502,224.49	1,220,444,108.90	0.00	-3,984,248,973.82	11,257,697,359.57

**2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**

№	Үзүүлэлтүүд		2023 он	2024 он		Зөрүү	Хувь
			Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
а	мян.м <sup>3</sup>	Цэвэр усны олборлолт	802.29	840.45	818.20	22.25	97.4
б	мян.м3	Борлуулсан ус	562.16	650.27	578.77	71.50	89.0

**Нийслэлийн Багануур дүүргийн Багануур-Ус ААТҮГ-ын 2024 оны санхүүгийн  
тайланд хийсэн аудитын тайлан**

в	мян.м <sup>3</sup>	Татан зайлуулсан бохир шингэн	516.69	583.62	536.71	46.91	92.0
г	мян.м <sup>3</sup>	Цэвэрлэж ариутгасан бохир ус	516.69	583.62	536.71	46.91	92.0
д	Гкал	Түгээсэн дулаан	27.88	28.00	31.52	(3.52)	112.6
<b>1</b>	<b>Нийт орлого</b>		<b>3,972,630.61</b>	<b>4,755,375.26</b>	<b>4,715,968.90</b>	<b>39,406.36</b>	<b>99.2</b>
1.1	Дулаан түгээх, зохицуулалттай хангах үйл ажиллагаа		1,408,658.26	1,600,799.28	1,525,858.51	74,940.77	95.3
1.2	Ус хангамжийн үйл ажиллагаа		1,270,583.00	1,555,805.67	1,528,428.62	27,377.05	98.2
1.3	Бохир шингэн татан зайлуулж цэвэрлэх үйл ажиллагаа		1,077,745.22	1,398,770.31	1,371,817.12	26,953.19	98.1
1.4	Үйл ажиллагааны бусад орлого		215,644.13	200,000.00	289,864.65	(89,864.65)	144.9
<b>2</b>	<b>Нийт зардал</b>		<b>4,166,787.87</b>	<b>5,007,533.10</b>	<b>4,822,965.19</b>	<b>184,567.91</b>	<b>96.3</b>
2.1	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг		739,542.47	880,439.60	837,465.60	42,974.00	95.1
	2.2.1	Цалин	1,631,727.40	1,958,072.90	2,013,095.91	(55,023.01)	102.8
	2.2.2	НДШ	228,511.10	274,130.20	292,923.56	(18,793.36)	106.9
	2.2.3	Үндсэн ба туслах материалын зардал	73,126.20	93,500.00	76,876.76	16,623.24)	82.2
	2.2.4	Шатахуун	74,871.70	95,000.00	81,922.05	13,077.95	86.2
	2.2.5	Сэлбэг хэрэгсэл / тоног төхөөрөмж	82,810.60	83,000.00	78,169.64	4,830.36	94.2
	2.2.6	Унаа хоолны зардал	102,782.00	160,272.00	124,308.00	35,964.00	77.6
	2.2.7	Хөдөлмөр хамгаалал	55,134.80	75,000.00	40,691.35	34,308.65	54.3
	2.2.8	ҮХЭлэгдэл	487,296.30	530,000.00	493,937.13	36,062.87	93.2
	2.2.9	Үл хөдлөх хөрөнгийн татвар	3,120.00	3,200.00	3,120.00	80.00	97.5
	2.2.10	Газрын төлбөр	12,650.70	12,700.00	10,999.40	1,700.60	86.6
	2.2.11	АТӨЯХ-ийн албан татвар	1,673.60	1,900.00	1,072.42	827.58	56.4
2.2	2.2.12	Ашиглалтын зардал	489,665.90	571,000.00	502,777.23	68,222.77	88.1
	2.2.13	Бичиг хэрэг шуудан холбоо	22,725.60	22,050.40	29,152.60	(7,102.20)	132.2
	2.2.14	Албан томилолт	3,802.00	7,648.00	5,132.00	2,516.00	67.1
	2.2.15	Зар сурталчилгаа, сургалт	2,882.60	12,950.00	33,175.00	(20,225.00)	256.2
	2.2.16	Бусад татвар даатгал	6,804.00	7,000.00	7,055.00	(55.00)	100.8
	2.2.17	Гадны үйлчилгээний хөлс	29,185.70	32,000.00	26,590.00	5,410.00	83.1
	2.2.18	Харуул хамгаалалт, программ үйлчилгээ	6,570.00	31,600.00	18,288.00	13,312.00	57.9
	2.2.19	Шагнал урамшуулал тэтгэмж	28,511.30	40,000.00	26,201.00	13,799.00	65.5
	2.2.20	Найдваргүй авлагын зардал	6,066.20	6,070.00	7,177.27	(1,107.27)	118.2
	2.2.21	Зээлийн хүү					
	2.2.22	Бусад	77,327.70	110,000.00	112,835.27	(2,835.27)	102.6

Нийслэлийн Багануур дүүргийн Багануур-Ус ААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

	<b>Үндсэн үйл ажиллагааны зардал</b>	<b>3,427,245.40</b>	<b>4,127,093.50</b>	<b>3,985,499.59</b>	<b>141,593.91</b>	<b>96.6</b>
2.3	Үйл ажиллагааны бус зардал					
<b>3</b>	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг алдагдал</b>	<b>(194,157.26)</b>	<b>(252,157.84)</b>	<b>(106,996.29)</b>	<b>(145,161.55)</b>	<b>42.4</b>
4	Орлогын татвар	213.87	300.00	953.71	(653.71)	317.9
<b>5</b>	<b>Цэвэр ашиг алдагдал</b>	<b>(194,371.13)</b>	<b>(252,457.84)</b>	<b>(107,950.00)</b>	<b>(144,507.84)</b>	<b>42.8</b>
6	Орлогын нэг төгрөгт ноогдох зардал	1.05	1.05	1.02	0.03	97.1
7	Нийт авлага бууруулах хэмжээ	411,932.85	370,740.00	320,713.14	50,026.86	86.5
8	Нийт өглөг бууруулах хэмжээ	885.45	5,000.00	361.84	4,638.16	7.2

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 22,000.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж алдаа, зөрчлийг дахин давтан гаргахгүй байх 1 албан шаардлага, 2 зөвлөмжийг өглөө.

Аудитаар илрүүлсэн 22,000.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 25,553.7 мянган төгрөгөөр бага тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

#### 3.1. Албан шаардлага

Тус байгууллага нь тайлант онд худалдан авах ажиллагааны босго үнээс давсан үнэтэй 22,000.0 мянган төгрөгийн бараа, ажил, үйлчилгээг сонгон шалгаруулалтгүйгээр шууд худалдаж авсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-т "Захиалагч тендер шалгаруулалтыг энэ хуулийн дөрөвдүгээр бүлэгт заасан аргаар зохион байгуулна", 31 дүгээр зүйлийн 31.1-т "Захиалагч ерөнхий гэрээний аргаар худалдан авахаас бусад тохиолдолд хуульд заасан төсөвт өртөгт үндэслэн тендер шалгаруулалтын дараах аргын аль нэгийн дагуу зохион байгуулна" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа сонгон шалгаруулалт зохион байгуулаагүй зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй ажиллах албан шаардлага хүргүүлэв.

#### 3.2. Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### 3.2.1. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг захирлын тушаал шийдвэрээр баталгаажуулаагүй, татвар, нийгмийн даатгал, нэмэгдсэн өртгийн албан татвар зэрэг холбогдох хууль журамд шинээр орсон нэмэлт өөрчлөлтийг тусгаагүй байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын "иж бүрэн байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг захирлын тушаалаар баталгаажуулах, холбогдох хууль журамд шинээр орсон нэмэлт өөрчлөлтийг тусган шинэчлэх.

##### 3.2.2. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлд элэгдлээрээ өртгөө нөхсөн, үлдэх өртөггүй 266 нэр төрлийн үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна.

**Нийслэлийн Багануур дүүргийн Багануур-Ус ААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

Энэ нь Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.1-т "Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.2-т заасан аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгийн үнэлгээний зүйлийг санхүүгийн тайлагналын зорилгоор үнэлэхэд ашиглана", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-т "санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын "иж бүрэн байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн, үлдэх өртөггүй үндсэн хөрөнгийг дахин үнэлж данс бүртгэлд тусгах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
ХАА-тай холбоотой	1	22,000.0			1	22,000.0							
НББББ-тэй холбоотой	1	0					1	0					
Үндсэн хөрөнгөтэй холбоотой	1	0					1	0					
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>22,000.0</b>			<b>1</b>	<b>22,000.0</b>	<b>2</b>	<b>0</b>					

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй	1	266,311.4			1	266,311.4
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>266,311.4</b>			<b>1</b>	<b>266,311.4</b>

Нийслэлийн Багануур дүүргийн Багануур-Ус ААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

**5.Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	<b>НИЙТ</b>	1	1			1			